



“ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 02-р сарын 08-ны өдөр

Г

Дугаар 01

Улаанбаатар хот

1

Хувьцаа эзэмшигчдийн хурал

хуралдуулах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн
ТОГТООХ НЬ :

Нэг. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04-р сарын 03-ны өдрийн 16.00 цагт компанийн байранд хуралдуулсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2020 оны 02-р сарын 13-ны дотор багтаан СХЗ-ны 2018 оны 377-р дугаар тогтоолын 3-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Б.Мөнхбатыг томилсугай.

Дөрөв. Хурал зохион байгуулах болон хурлын тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй ажиллуулсугай.

Үүнд: Ж.Дүгэржав

О.Шинэхүү

Г.Гантуяа

Тав. Хурлаар дараахь асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Бусад

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.МӨНХБАТ